



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2017 он 04 дугаар
сарын 27 ны өдөр

Дугаар Хэрг / 695

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
М.ЭНХБОЛД ТАНАА

Ерөнхий сайдын мэдээллийн тухай

Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат Улсын Их Хурлын 2017 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд зам тээвэр, барилга хот байгуулалтын салбарын бүтээн байгуулалтын явцын талаар мэдээлэл хийх болсныг Танд үүгээр уламжилж байна.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ж.МӨНХБАТ

**ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЛБАРЫН БҮТЭЭН
БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ЯВЦЫН ТАЛААР УЛСЫН ИХ ХУРЛЫН
ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД ЕРӨНХИЙ САЙД
Ж.ЭРДЭНЭБАТЫН ХИЙХ МЭДЭЭЛЭЛ**

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЛБАРЫН БҮТЭЭН
БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ЯВЦЫН ТАЛААР**

Нэг.Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр

Барилгын салбарын хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн бодлогыг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн хөгжүүлэх, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор барилга, барилгын материалын салбарт баримтлах бодлогыг шинэчлэх, барилгын материалын үйлдвэрлэлийг дотоодын нөөц бололцоог ашиглан бүсчлэн хөгжүүлэх, улмаар гадаадад экспортлох боломжийг бүрдүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Уг ажлын хүрээнд байгаль орчинд ээлтэй, дулаан алдагдалгүй, бууруулсан, галд тэсвэрлэлтийг нь сайжруулсан барилгын материал үйлдвэрлэх зорилгоор барилгын угсармал хийц бүтээцийн үйлдвэр, дулаалгын материал, төмөрлөгийн үйлдвэрүүдийг бодлогоор дэмжин, эрх зүйн орчныг боловсронгуй болгохоор ажиллаж байна. Мөн түүнчлэн Замын-Үүдийн чөлөөт бүсэд барилгын материалын бөөний хангамжийн сүлжээг байгуулах болон Налайх дүүрэгт баригдах барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк болон Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний зураг төслийн санхүүжилтийг шийдвэрлүүлэн зураг төсөл боловсруулах ажлыг эхлүүлээд байна.

Өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөрөнгө оруулалтын үр дүнд шинээр ашиглалтад орсон үйлдвэрүүд, орохоор төлөвлөгдсөн үйлдвэрүүдийн үр дүнд 2017 оны 1 дүгээр улирлаас эхлэн цементийн үйлдвэрүүд дотоодын хэрэглээг 100 хувь хангаж, улмаар экспортлох боломжтой болоод байна.

Дээрх хөтөлбөрийн хүрээнд 2015 оны байдлаар өссөн дүнгээр 75 компани 200 гаруй тэрбум төгрөгний зээлд хамрагдсаны үр дүнд 21 үйлдвэр шинээр болон шинэчлэн байгуулах, давхардсан тоогоор 21 үйлдвэр тоног төхөөрөмжөө, 27 үйлдвэр эргэлтийн хөрөнгөө сайжруулан ажиллаж 21 үйлдвэр ашиглалтад ороод байна.

Барилгын материалд шаардлагатай эрдэс түүхий эдийн ордын нөөц хэмжээг төрөлжүүлэн судлахад керамикийн түүхий эдийн нөөц 221.9 сая м.куб, үүнээс үйлдвэрийн нөөцөөр 12.6 хувь, дүүргэгч материалын нөөц 384.7 сая м.куб үйлдвэрлэлийн нөөцөөр 12.4 хувь, барьцалдах материалын түүхий эд 292.2 сая тонн, үйлдвэрлэлийн нөөцөөр 13.6 хувь, хөнгөн дүүргэгчийн нөөц 49.8 сая м.куб үүнээс үйлдвэрийн нөөцөөр 18.1 хувь нь тогтоогдсон байна.

Хоёр.Орон сууц, нийтийн аж ахуйн чиглэлээр

2.1.Орон сууц, түрээсийн орон сууц хөтөлбөрийн хүрээнд:

2017 оны 2 дугаар сарын байдлаар /энэ онд/ 909 зээлдэгч шинээр ипотекийн зээлд хамрагдсанаар нийт зээлдэгчийн тоо 89823-т хүрсэн байна. Үүний 66166 буюу 73.7% нь орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр (ОСИСТТБХ)-ийн зээлтэй байна.

Ипотекийн зээлийн үлдэгдэл 4,062.8 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүний 3158.12 тэрбум төгрөг буюу 77.7% нь ОСИСТТБХ-ийн зээл байна. Тухайн сард олгосон зээлийн дундаж хүү 10.3%, жигнэсэн дундаж хугацаа 18.2 жил, нэг зээлдэгчид ногдох хэмжээ дунджаар 64.5 сая төгрөг байна. Ипотекийн зээлийн үлдэгдэлд эзлэх хугацаа хэтэрсэн зээл 2.8%, чанаргүй зээл 1.6% байна.

Мөн түүнчлэн орон сууц худалдан авах боломжгүй, түрээсийн орон сууцанд амьдрах сонирхолтой иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн өмчийн бүх хэлбэрийн түрээсийн орон сууцны санг бүрдүүлж, иргэдийн орон сууцны хангамж, нөхцөлийг сайжруулах зорилгоор Засгийн газрын 2015 оны 248 дугаар тогтоолоор баталсан “Түрээсийн орон сууц” хөтөлбөр 2015-2021 оны хугацаанд хэрэгжих бөгөөд уг хөтөлбөрийн хүрээнд нийслэлд 16000 айлын, аймгуудын төвд 4000 айлын түрээсийн орон сууцны санг бүрдүүлэхээр, эдгээрийн 12160 айлын орон сууцны санг шинээр, 7840 айлын орон сууцны санг зах зээл дээр ашиглагдаж байгаа түрээсийн байрнуудын эрүүл ахуйн нөхцөл, шаардлагыг хангуулах замаар бүрдүүлнэ.

Түрээсийн орон сууцны нэг сарын түрээсийн төлбөрийн хэмжээг Үндэсний статистикийн хорооноос гаргадаг жил бүрийн “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-д тулгуурлан өрхийн дундаж орлогын 25 хувиас хэтрэхгүй байхаар хот, хөдөөд ялгавартай тогтоон мөрдүүлж байгаа бөгөөд Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 25 дугаар тушаалаар 2017 онд мөрдөх түрээсийн орон сууцны нэг сарын түрээсийн төлбөрийн хэмжээг нийслэлд 6000 төгрөг, орон нутагт 4500 төгрөг байхаар тус тус тогтоон мөрдүүлж байна.

Мөн Улаанбаатар хотод БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр “Бэрэн” группын барьж ашиглалтад оруулсан “Хангай” хорооллын 223 айлын орон сууцыг төрийн түрээсийн орон сууцны санд шилжүүлэхээр Засгийн газрын 2016 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 298 дугаар тогтоолоор шийдвэрлэснээр 2016 онд нийт 1152 айлын төрийн өмчийн түрээсийн орон сууцны санг бүрдүүллээ.

Байршил	Орон сууцны хүчин чадал (айлын тоо)
Архангай аймгийн төв	120
Увс аймгийн төв	84
Дархан-Уул аймгийн төв	83
Сэлэнгэ аймгийн Зүүн Хараа	90
Хэнтий аймгийн төв	96
Ховд аймгийн төв	96
Хэнтий аймгийн Бор-Өндөр	10
Орон нутгийн хэмжээнд, нийт	579
Улаанбаатар хот “Буянт-Ухаа 2” хороолол	350

Улаанбаатар хот “Хангай” хороолол	223
Улсын хэмжээнд, нийт	1152

Дундговь аймаг 2015 онд Орон нутгийн хөгжлийн сангийн 300,0 сая төгрөгөөр 54 м2 талбай бүхий 6 айлын орон сууцыг, Орхон аймаг 2016 онд 1-2 өрөө бүхий 40 орон сууцыг худалдан авч, орон нутгийн өмчийн түрээсийн 46 айлын орон сууцны санг бүрдүүлсэн байна. Бусад аймгуудын хувьд ТОСК-ийн захиалгаар баригдсан төрийн түрээсийн орон сууцны инженерийн дэд бүтцийг барих, орон сууцанд иргэдийг хамруулах зэрэгт дэмжлэг үзүүлэн ажилласан байна.

Дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Төрийн орон сууцны корпораци” ТӨҮГ-ын захиалгаар баригдаж ашиглалтад орсон 929 айлын орон сууцыг төрийн түрээсийн орон сууцны санд шилжүүлэх асуудлыг Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 38 дугаар тогтоолоор шийдвэрлүүлэн, түрээсийн үйл ажиллагааг Улаанбаатар хот болон 6 аймагт эхлүүлээд байна.

Орон нутагт:

Засгийн газраас хэрэгжүүлж буй “Аймаг бүрт 1000 айлын орон сууц” хөтөлбөрийн хүрээнд 2016 оны 12 дугаар сард Хэнтий аймгийн Хэрлэн суманд 120 айлын орон сууц ашиглалтад өгөв. /Хавсралт №1/

Мөн 2017 оноос Орхон аймагт 315 айлын, Хөвсгөл аймагт 135 айлын, Говь-Алтай аймагт 120 айлын дуусаагүй орон сууцны барилгуудыг үргэлжлүүлэн барьж байгуулна. /Хавсралт №2/

Улаанбаатар хотод:

Улаанбаатар хотод “Буянт ухаа 2” орон сууцны хорооллын дуусаагүй 972 айлын 18 барилгыг үргэлжлүүлэн 2017 оны 4 дүгээр улиралд ашиглалтад оруулна.

Мөн 2017 оноос хэрэгжихэд бэлэн болсон дараах 5 орон сууцны хороолол, хотхоны төслийг эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна:

“Буянт ухаа 2-2”, “Буянт ухаа-3”, “Эко яармаг”, “7 дугаар хороолол”, “ТОСК-999” төсөл. Үүнээс гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд “Эко яармаг”, “7 дугаар хороолол”, “ТОСК-999” төслүүд хэрэгжих юм.

Эдгээр 770.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй төслүүд хэрэгжснээр нийт 8717 айлын хямд өртөгтэй орон сууц ашиглалтад орох боломжтой болно. /Хавсралт №3/

Түрээсийн орон сууц хөтөлбөрийн хүрээнд:

Засгийн газраас хэрэгжүүлж буй “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хүрээнд дээр дурдсан хугацаанд нийт 1512 айлын орон сууцыг түрээсийн орон

сууцны санд шилжүүлж холбогдох арга хэмжээг зохион байгууллаа. /Хавсралт №4/

Үүнээс ТОСК-ийн 80.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар нийт 1287 айлын орон сууц, бусад хөрөнгө оруулагчаас 223 айлын орон сууц түрээст шилжсэн байна.

Цаашид гэр хорооллын иргэдийг орон сууцжуулах чиглэлээр Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, зээлийн цар хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх, “Ногоон хувийн орон сууц” загвар төслийг үе шаттайгаар хэрэгжүүлэх, аймаг бүрт “1000 айлын орон сууц” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, “Түрээсийн орон сууц хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, 20000 айлын түрээсийн орон сууцны санг бүрдүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгаад байна.

2.2.Сумын төвийн шинэчлэл төслийн хүрээнд:

Сумын төвийн шинэчлэл төсөл нь 16 аймгийн 16 сумын төвд ус хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, дулаан, цахилгааны шугам сүлжээ, барилга байгууламж барьж хүн амын ажиллаж, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилготой хэрэгжиж байна.

Төслийг улсын төсвийн 80,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2013 оноос хойш хэрэгжүүлж байгаа бөгөөд уг төслийн хүрээнд Баян-Өлгий аймгийн Цэнгэл, Булган аймгийн Хутаг-Өндөр, Завхан аймгийн Тосонцэнгэл, Өвөрхангай аймгийн Богд, Сэлэнгэ аймгийн Цагааннуур, Төв аймгийн Лүн, Ховд аймгийн Зэрэг, Увс аймгийн Тэс, Өмнөговь аймгийн Цогт-Овоо зэрэг 9 сумын ажлыг байнгын ашиглалтад оруулж, Хөвсгөл аймгийн Цэцэрлэг, Архангай аймгийн Тариат, Дундговь аймгийн Өлзийт, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Хэнтий аймгийн Биндэр зэрэг 7 сумын ажил 60-90 хувьтай байгаа ба 2017 онд ашиглалтад хүлээлгэн өгөхөөр төлөвлөж байна.

Дээрх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд аймаг, нийслэлд дулааны шугам 100 км, цэвэр усны шугам 350 км, бохир усны шугам 220 км, 29 гүний худгийг шинээр ашиглалтад оруулж, 14 цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчилснээр ус, дулаан хангамж, ариутгах татуургын хүчин чадал нэмэгдэж, найдвартай ажиллагаа сайжирч, хүн амын ажиллаж, амьдрах нөхцөл сайжирсан байна. /Хавсралт №5/

“Сумын төвийн шинэчлэл” төсөл хэрэгжиж байгаа Архангай, Дундговь, Өмнөговь, Хөвсгөл, Ховд аймгийн шугам сүлжээний ажлын үлдэгдэл санхүүжилтийг шийдвэрлүүлэн энэ онд дуусгахаар ажиллаж байгаа бөгөөд Говь-Алтай, Хөвсгөл, Сэлэнгэ, Дорнод аймгийн ажлуудыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.

Гурав.Салбарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн явцын талаарх мэдээлэл

3.1.2013-2017 онд хэрэгжиж буй “Эрдэнэт хотын бохир ус, цэвэрлэх байгууламжийн өргөтгөл төсөл”-ийн хүрээнд:

Эрдэнэт хотод хоногт 24000 м³ бохир ус цэвэрлэх байгууламжийг шинээр барих

Франц улсын Засгийн газрын 9.535.000 евро буюу 17163.0 сая төгрөг, Монгол Улсын Засгийн газрын 9.224.8 тэрбум төгрөгийн төсөвтэй. Нийт 26387,0 сая төгрөг, үүнээс улсын төсвөөс 6800,0 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн. Үлдэгдэл 2424.8 сая төгрөг байна.

Цэвэрлэх байгууламжийн барилга угсралттай холбоотой дараах ажлууд хийгдэж байна:

Элс баригчийн байгууламж нь 8 м голчтой, 5.47 м гүнтэй бөгөөд элс, өөх тос цуглуулах худагтай, бүрэн цутгамал байгууламжтай бөгөөд барилга угсралтын ажлын гүйцэтгэл 100%;

Анхдагч тунгаагуурын байгууламжууд нь 20 м голчтой, А, В хэсэгтэй, ул бетон болон суурийн арматурчлал, ус өгөх Ф600 мм болон лагийн Ф89 мм шугам, ханын арматурчлал 1.2 м-ын түвшинд хийгдсэн. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 100 хувьтай. Хоёрдогч тунгаагуурын ажил 35%;

Цахилгааны дэд станцын барилга нь 12.7х8м хэмжээтэй төмөр каркасан бүтээцтэй 51 см ханатай, нэг давхар тоосгон барилга бөгөөд дотор заслын ажлууд хийгдсэн. Цахилгааны өрөөний давхар шал, хаалганууд, газардуулга, орох гарах шатнууд, аянга зайлуулагч бүрэн хийгдсэн. Мөн ЦРП-6-аас цахилгааны дэд станц хүртэл өндрийн кабель шугам татах ажил бүрэн хийгдсэн. Барилга угсралтын ажил 95%;

Агаарын насосны станцын тоног төхөөрөмжийн суурийн цутгалт, шал, дээврийн хашлага, бохир усны болон цахилгааны шугам сүлжээний худгийн барилга угсралтын ажил 100%;

Лаг усгүйжүүлэх байгууламжийн лаг өтгөрүүлэгч ба лагийн насосны станцад тоног төхөөрөмжүүдийг угсарч, дотор заслын ажил хийгдэж байна. Барилга угсралтын ажил 100%;

Аэротенк нь 7000 м³ багтаамжтай А болон В гэсэн 2 блок хэсэгтэй барилга угсралтын ажил 85%;

Төслийн Удирдах хороог Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 150 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан.

Тоног төхөөрөмжийн суурилуулалт 65% байна.

3.2.2011-2016 онд хэрэгжиж буй “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд:

Замын-Үүд сумын дэд бүтцийг шинэчлэн сайжруулах, Замын-Үүдийн эдийн засгийн чөлөөт бүсийн 3, 4 дүгээр хэсгийн дэд бүтцийг шинээр барьж байгуулах зорилготой.

БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр 58.8 сая долларт хэрэгжиж буй “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах ZU-05/09 төсөл” нь Замын-Үүдийн эдийн засгийн чөлөөт бүсийн 3, 4 дүгээр хэсгийн дэд бүтцийг шинээр барьж байгуулах зорилгоор дараах 4 багц арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна:

Дулаан хангамж: 90МВт хүчин чадалтай дулааны станцын барилга, тоног төхөөрөмжийн суурилуулалтын ажил бүрэн хийгдсэн;

Замын-Үүд сум болон Чөлөөт бүсэд нийт дулаан дамжуулах төв 7 ш, дулааны шугам 20.5 км-ийг шинээр барьсан;

Ус хангамж, ариутгах татуурга: Замын-Үүд сум болон Чөлөөт бүсэд нийт 3200 м³/хоног хүчин чадалтай ус цэвэршүүлэх үйлдвэр, 3500м³/хоног хүчин чадалтай бохир усны цэвэрлэх байгууламж, цэвэр усны гүний худаг 3ш, 500 м³-н усан сан 4ш, өргөлтийн насос станц, бохир усны түрэлтийн станц 4ш, цэвэр усны 37,3 км шугам сүлжээ, бохир усны 10,4 км шугам, саарал усны 6 км шугам барьсан бөгөөд барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах улсын комисс 2016.06.08-нд ажиллаж, ашиглалтад хүлээлгэн өгсөн.

Цахилгаан хангамж: Замын-Үүд сумын 110/10 кВ-ын дэд станцыг өргөтгөж, 8х5 м барилга барьж, 2 ячейкийг суурилуулж хүчдэлд залгасан.

Чөлөөт бүс дэх 110/10 кВ-ын ил хуваарилах байгууламж, 10/0,4 кВ-ын дэд станц 16 ш, 10 кВ-ын далд хуваарилах байгууламж 2 ш, чөлөөт бүсэд 6/10 кВ-ын кабель шугам 33.67 км, 10 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам 19.3 км, 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам 2.8 км-ийг тус тус барьж ашиглалтад оруулсан.

Автозам, холбоо: 12.8 км авто зам, 78000 м² явган хүний зам, 1184 ш гэрэлтүүлэг, 14 км холбооны сувагчлалын ажлыг гүйцэтгэж, 7000 м² талбайд замын тэмдэг, тэмдэглэгээг хийсэн.

Төслийн хүрээнд баригдсан дулааны станцыг байнгын ашиглалтад хүлээн авах улсын комисс ажиллуулахаар бэлтгэл ажлыг хангаж, дулааны станцын туршилт, тохируулга болон нүүрс татан авахад шаардагдах санхүүжилтийг 2017 оны улсын төсөвт тусган шийдвэрлүүлсэн. Туршилт тохируулгын ажил хийгдэж байна.

3.3.2015-2019 онд хэрэгжиж буй “Дархан хотын бохир усны менежментийн МОН 3244/3245 төсөл”-ийн хүрээнд:

Дархан хотод хоногт 20000 м³ бохир ус цэвэрлэх байгууламжийг шинээр барих

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр 20,8 сая.ам долларын төсөвтэй.

Төслийн үр дүнд дараах ажлуудыг хийнэ:

- Шинэчилж сайжруулсан орчин үеийн цэвэрлэх байгууламж;
- Одоо ажиллаж байгаа бүрэлдэхүүн хэсгүүдийг шинэчлэх;
- Шинэ бүрэлдэхүүн хэсгүүдийг талбай дээр шинээр барих;
- Байгууламжийн хэмжээнд шинэ тоног төхөөрөмж нэвтрүүлэх;
- Шинэчилсэн өргөх насос станц болон бохирын шугам хоолой.

5400 метр шугам хоолойг шинэчлэх 2 өргөх насос станцыг шинэчлэх, шинэ тоног төхөөрөмж суурилуулах ажлууд хийгдэх болно.

Төслийн үндсэн зөвлөхөөр Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын "FICHTNER" компани, Монгол Улсын "ИКОН" ХХК шалгарч манай орны уур амьсгалд зохицсон технологи бүхий цэвэрлэх байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичгийг боловсруулан холбогдох байгууллагаас санал авч бэлтгэл ханган ажиллаж байна.

Мөн Дархан хотын НААҮ-ний "Дархан Ус суваг" ХК-ийн стратеги, төлөвлөлт ба үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр дэмжлэг үзүүлэх техникийн туслалцааны төсөл хэрэгжиж байна.

3.4.2013-2017 онд Монгол Улсын Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй "Дэд бүтэц" төслийн хүрээнд:

Улсын Их Хурлын 2010 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хүрээнд Засгийн газрын 2013 оны 118, 2014 оны 263 дугаар тогтоолын дагуу Засгийн газрын үнэт цаасыг арилжаалж бүрдүүлсэн Чингис бондын хөрөнгөөр санхүүжигдэж, Улаанбаатар хотод баригдаж буй орон сууцны хотхон, хорооллуудын цахилгаан, дулаан, ус хангамж, ариутгах татуургын барилга байгууламж, шугам сүлжээг барьж, дэд бүтцийг цогцоор нь шийдвэрлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор "Дэд бүтэц" төсөл 2013 оноос эхлэн хэрэгжсэн.

Уг төсөл нь 6 зорилт, 27 төсөл арга хэмжээний хүрээнд Буянт-Ухаа, Баянголын ам, Ирээдүй, Солонго, Яармаг, VII, XIV, МҮОНРТ-ийн орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээг цогцоор нь шийдвэрлэхэд нийтдээ 126.8 тэрбум төгрөг шаардагдахаас 2016 оны жилийн эцсийн байдлаар 87.6 хувийн санхүүжилт хийгдэж, төслийн хэрэгжилт 94.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

"Дэд бүтэц" төслийн хүрээнд инженерийн барилга байгууламж, шугам сүлжээний нийт 27 төсөл, арга хэмжээнд 126.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий ажил гүйцэтгэж, төслийн хэрэгжилт дунджаар 94.5 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

Төсөл хэрэгжүүлсний үр дүнд өнөөдрийн байдлаар "Буянт-Ухаа-1", "Буянт-Ухаа-2" хороолол, VII хорооллын "Хангай", "Ирээдүй цогцолбор", "Баянголын ам", "Шинэ Яармаг", "Шинэ өргөө" хороолол, "Ханбогд резиденс" хорооллууд тус тус баригдан ашиглалтад ороод байна.

Эдгээр инженерийн дэд бүтцийн барилга, байгууламж, шугам сүлжээнүүдийг бүрэн ашиглалтад оруулснаар шинээр төлөвлөгдсөн дээрх хорооллуудад нийтдээ 70600 айлын орон сууц, 26700 хүүхдийн сургууль, 11500 хүүхдийн цэцэрлэг, өдөрт 4650 хүнд үйлчилгээ үзүүлэх эмнэлэг, 2000 ажлын байр бүхий үйлчилгээ, худалдааны төв, спорт цогцолбор, соёлын төв, конторын барилга байгууламжууд баригдах боломж бүрдэнэ.

3.5.2011-2017 онд Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй “Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн G0204-МОН төсөл”-ийн хүрээнд:

Төсөлд хамрагдаж буй сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, нэн тэргүүнд шаардагдах дэд бүтцийн барилга байгууламжийг барих, түүний ашиглалт, үйлчилгээг хариуцах оператор компанийг байгуулж чадавхжуулах зэрэг ажлуудыг хамарсан цогц шийдэл гаргах, хотуудын хөгжлийг үр ашигтай, зөв төлөвлөх, чанартай, найдвартай, өргөн хүрээг хамарсан нийтийн аж ахуйн үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлэх зорилготой.

Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламж 15.0 сая ам.доллар, Монгол Улсны Засгийн газрын санхүүжилт 6.9 сая ам.долларын санхүүжилттэй. Төсөлд уул уурхайн үйл ажиллагаа төвлөрсөн стратегийн чухал ач холбогдол бүхий төв суурин газрууд болох Өмнөговь аймгийн Даланзадгад, Ханбогд, Цогтцэций, Гурвантэс болон Дорноговь аймгийн Сайншанд, Замын-Үүд сум хамрагдана.

Төслийн хэрэгжилт: Төслөөр Дорноговь аймгийн Сайншанд сум, Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтцэций, Гурвантэс сумдын 2025 он хүртэлх “Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” болон “Шинэ Сайншанд” орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулсан. Төслийн сумдад ундны эх үүсвэрийн 3 ш гүний худаг, 3 ш усан сан, 39.5 км цэвэр усны шугам, 35.88 км ариутгах татуургын шугам, 12.52 км дулааны шугам, гэр хороололд 11 ш ус түгээх байр шугам сүлжээнд холбосон, бохир усны насос станц 4 ш, цэвэрлэх байгууламж 200 м3/хон, 680 м3/хон-гийн 2 ш, 10.6 км цахилгаан дамжуулах шугам, дулаан дамжуулах төв 3 ш, дизель цахилгаан үүсгүүр 3 ш, 8.4 Мвт хүчин чадалтай дулааны зуух, 6 км автозам, 1.8 км үерийн хамгаалалтын далан тус тус барьж ашиглалтад хүлээлгэн өгсөн. Мөн сумдад 12 ш хог хаягдлын машин механизм нийлүүлсэн. Шинээр баригдсан шугам сүлжээ, барилга байгууламжийн ашиглалт, үйлчилгээг хариуцах оператор компаниудыг байгуулсан. Төслийн үр шимийг 2015 оны байдлаар 6 сумын төвийн нийт 74.500 хүн хүртэж байгаа бөгөөд 2025 оны түвшинд 125.000 мянган хүн үр шимийг хүртэх техникийн боломжтой болсон.

3.6.2016-2019 онд Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжиж буй “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт-бохир усны менежментийг сайжруулах төсөл”

Дорноговь аймгийн Сайншанд, Өмнөговь аймгийн Даланзадгад, Архангай аймгийн Цэцэрлэг, Өвөрхангай аймгийн Арвайхээр хотод бохир усны биологи цэвэрлэгээний байгууламжийг барих, цэвэрлэгдсэн бохир усыг зайлуулах

стандартыг хангах, цэвэрлэгдсэн усыг дахин ашиглах нөхцөлийг бүрдүүлэх, орон нутгийн байгаль орчныг сайжруулж, бохирдлыг бууруулах зорилготой.

Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хооронд байгуулах “Зээлийн хэлэлцээр”-ийг 2016 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 16-ны өдрүүдэд хэлэлцэн байгуулсан. Зээлийн хэлэлцээрт Азийн хөгжлийн банк, Сангийн яам, Өмнөговь, Дорноговь, Архангай, Өвөрхангай аймгийн Засаг дарга нар гарын үсэг зурж, баталгаажуулсан. Төслийн зээлийн гэрээг 2016 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы 2016 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар соёрхон батлуулсан. Дээрх аймгуудад барих цэвэрлэх байгууламжийн зураг төслийг боловсруулан батлуулсан.

Дорноговь аймгийн орон нутгийн хүсэлтэд үндэслэн Сайншанд хотын цэвэрлэх байгууламжийн хүчин чадлыг 4200м³/хон-оос 3000м³/хон болгон бууруулах, байршлыг өөрчлөх, хэмнэсэн хөрөнгөөр нэмэлт бохир усны өргөтгөлийн шугам барих асуудлыг судлан үзэж, холбогдох орон нутгийн удирдлагын шийдвэрийг оруулан төслийн удирдах хороонд танилцуулж дэмжүүлсэн.

Төслийн хэрэгжилтийн дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээний багцын үнэлгээний хороо томилогдон зөвлөхийн ажлын даалгавар баталсан ба Азийн хөгжлийн банкны цахим хуудсанд зөвлөхийн зарыг нийтэлж, дэлгэрэнгүй жагсаалтаас хураангуй жагсаалт үүсгэх үнэлгээг гүйцэтгэж, дүгнэлтийг Азийн хөгжлийн банкинд хүргүүлээд байна.

Төслийн аймгуудын НААҮБ-ын чадавхыг бэхжүүлэх зөвлөх үйлчилгээний үнэлгээний хороо томилогдон ажлын даалгаврыг боловсруулан баталж, Азийн хөгжлийн банкинд 2016 оны 12 дугаар сарын 14-ний өдөр хүргүүлсэн.

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо, суурин газруудын хөгжлийн төсөл-нэмэлт санхүүжилт”-ийн төслийн хүрээнд Архангай, Өвөрхангай, Өмнөговь, Дорноговь аймгийн цэвэрлэх байгууламжийн төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд Дорноговь, Өвөрхангай аймгийн цэвэрлэх байгууламжуудын барилга угсралтын ажлыг энэ онд, үлдсэн 2 аймгийг 2018 онд хэрэгжүүлж эхлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.

3.7.2011-2016 онд хэрэгжиж буй “Улаанбаатар хотын VII, XIV хорооллын орон сууц, VII, МҮОНРТ орчмын хорооллын дэд бүтцийн төсөл”-ийн хүрээнд:

Улаанбаатар хотын орон сууцны VII, МҮОНРТ орчмын хорооллуудын гадна инженерийн шугам сүлжээг барьж байгуулах, Нийслэлийн VII, XIV хороололд 2592 айлын орон сууцны 36 барилга барихад оршино.

Төслийн нийт санхүүжилт 117.5 сая ам.доллар, үүнээс БНХАУ-ын Засгийн газраас 100.0 сая ам.доллар, Монгол Улсын Засгийн газраас 17.5 сая ам.доллар. Орон сууцны барилга барих төсөвт өртөг 70.5 сая ам.доллар, ИШС-

ний угсралтын ажлын төсөвт өртөг нь 47,05 сая ам.доллар байна. Нийт авсан санхүүжилт 85 хувь буюу 99,8 сая ам.доллар.

Төслийн ерөнхий гүйцэтгэгчээр БНХАУ-ын “Бээжин констракшн инженеринг” ХХК ажиллаж байна. ЗТБХБЯам тус компанитай 2010 онд гэрээ байгуулсан. БЗА-2010/55-БАРИЛГА/172 дугаартай барилгын гэрээг 2014, 2015, 2016 онд, БЗА-2010/55-ИШС дугаартай инженерийн шугам сүлжээний гэрээг 2014, 2016 онд тус тус сунгасан.

Улаанбаатар хотын VII, XIV хороололд барих 36 барилга буюу 2592 айлын орон сууцны барилга угсралтын ажлын явц 95 хувьтай байна. Үүнээс:

1. Сүхбаатар дүүргийн VII хороололд “Бэрэн групп” ХХК-ийн чөлөөлсөн газар дээр 72 айлын орон сууцны 25 барилга буюу 1800 айлын орон сууц баригдахаас 18 барилга буюу 1296 айлын орон сууц ашиглалтад орсон;
2. Баянзүрх дүүргийн XIV хороололд “Бэрэн групп” ХХК /1 барилга/ болон “Цагаанхуаран консалтинг” ХХК-ийн /10 барилга/ чөлөөлсөн газар дээр 72 айлын орон сууцны 11 барилга буюу 792 айлын орон сууц баригдаж ашиглалтад орсон;
3. Орон сууцны VII хорооллын инженерийн шугам сүлжээний угсралтын ажлын гүйцэтгэл 92.1 хувь;
4. МҮОНРТ-ын орчмын хорооллын инженерийн шугам сүлжээний угсралтын ажлын гүйцэтгэл 38 хувь;
5. УБ хотын VII хороолол, МҮОНРТ-ийн орчмын хорооллыг цахилгааны эх үүсвэрээр хангах 24.3 км агаарын шугам болон “Улаанбаатар” дэд станцын өргөтгөл, “7 дугаар хороолол”, “Радио телевиз” дэд станцын угсралтын ажил бүрэн хийгдсэн.

Дөрөв.Хот байгуулалтын чиглэлээр

Хөшигийн хөндийд шинээр баригдсан олон улсын нисэх онгоцны буудлыг даган бий болох “ухаалаг” жишиг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх, эхний ээлжийн барилгажилтын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах асуудлыг Засгийн газрын 2017 оны 105 дугаар тогтоолоор батлан Төв аймгийн хөшигийн хөндийд баригдах нисэх онгоцны буудлыг даган хөгжих шинэ хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийж, шинэ хот байгуулах, түүнийг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

4.1.Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх, төлөвлөх ажлын хүрээнд:

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор хуулийг дагалдах дүрэм, журмын төсөл боловсруулж батлуулах ажлын хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэсэн:

“Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэх талбайг сонгох үлгэрчилсэн журам”, “Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төсөлд оролцогчдын хооронд байгуулах гурван талт гэрээний үлгэрчилсэн загвар”, “Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөлд оролцогчдын хооронд байгуулах гурван талт гэрээний үлгэрчилсэн загвар”, “Ашиглалтын шаардлага

хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих төсөлд оролцогчдын хооронд байгуулах гурван талт гэрээний үлгэрчилсэн загвар”, “Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам”-ыг Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар батлуулан захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн.

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, бүтээн байгуулалтын ажлын хүрээнд иргэдийг ажилтай, орлоготой болгох, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн баталгааг хангах зорилгоор 2013 оноос эхлэн нийслэлийн нийт 24 байршилд гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах 8 байршлыг сонгон төсөл хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Дээрх 32 байршилд нийтдээ 85190 хүн ам бүхий 17667 нэгж талбарын 1615.8 га талбай хамрагдсан. Энэ нь нийслэлийн гэр хорооллын нутаг дэвсгэрийн 15 хувь, гэр хорооллын хүн амын 10 хувийг хамарч байна.

“Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл” хэрэгжиж эхэлсэн 3 жилийн хугацаанд нийт 1465 нэгж талбарын 90 га газрыг чөлөөлөн 9654 айлын орон сууцны барилга угсралтын ажлыг эхлүүлээд байгаа бөгөөд 2014 онд 960 айлын орон сууц, 2015 онд 1656 айлын орон сууц, 2016 онд 2213 айлын орон сууцыг тус тус ашиглалтад оруулж, гэр хорооллын 957 өрхийг шинэ орон сууцаар хангаад байна.

2013-2016 оны байдлаар орон сууцны барилга, бүтээн байгуулалт, нийгмийн дэд бүтцийн болон инженерийн дэд бүтэц, автозамын барилга угсралтын ажилд зориулан гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэгч 34 компаниас 21 төсөл хэрэгжүүлэгч нийт 1465 нэгж талбарын 90 га газрыг чөлөөлөөд байна. Дээрх нэгж талбараас 957 айл өрхийг гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн хүрээнд баригдсан орон сууцаар хангаж, 24 нэгж талбарыг бэлэн мөнгөөр худалдан авсан бол нийт 484 нэгж талбарын иргэдийг түрээсийн байраар хангаад байна.

“Гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл”-ийн нэг гол онцлог нь иргэдийн одоо амьдарч байгаа газар, үл хөдлөх эд хөрөнгийг чөлөөлөн бүтээн байгуулалт хийх явдал юм. Газар чөлөөлөхдөө 2013-2016 оны хооронд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 3/31 дүгээр тогтоол, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны журам”, “Гурван талт гэрээний загвар”-т заасны дагуу газар, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эзэмшигчийн газар, үл хөдлөх эд хөрөнгийг бэлэн мөнгөөр худалдан авах, газар, үл хөдлөх эд хөрөнгийг орон сууцаар солих, бусад гэсэн үндсэн гурван хэлбэрээр тохиролцож чөлөөлж ирсэн. Дээрх тохиролцоог төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, газар, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эзэмшигч нь сайн дурын үндсэн дээр харилцан тохиролцож шийдвэрлэж ирсэн бөгөөд тус тохиролцоонд хөндлөнгөөс нөлөөлдөггүй болно.

Монгол Улсын макро эдийн засгийн хямрал тэр дундаа үл хөдлөх, барилгын салбарт тулгараад буй хямралаас үүдэн “гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл” хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүд иргэдийн өмнө хүлээсэн түр суурьшуулах байраар хангах үүргээ биелүүлж чадахгүй нөхцөл байдал үүсч байна. Өнөөдрийн байдлаар “гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл” хэрэгжүүлэгч 3 аж ахуйн нэгж иргэдэд олгох түрээсийн зардлыг огт олгохгүй байгаа бол 5 аж ахуйн нэгж удаашралтай буюу хоцрогдолтой байна.

Дээрх үүсээд буй нөхцөл байдалтай холбогдуулан “гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл”-ийн хүрээнд газар, үл хөдлөх эд хөрөнгөө чөлөөлсөн боловч түр суурьшуулах байраар хангагдаж чадахгүй, гэрээнд заасан хугацаанд орон сууцаар хангагдаагүй хохирч байсан иргэдийн асуудлыг шийдвэрлэхээр Нийслэлийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

Ажлын хэсгээс гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүд, гэрээний дагуу түрээсийн орон сууцаар хангагдаж чадахгүй, гэрээнд заасан хугацаанд орон сууцаар хангагдаагүй хохирч байсан иргэдтэй уулзалт зохион байгуулж улмаар “Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл”-өөс үүдэн хохирсон 180 өрхийг түр суурьшуулах байраар хангах замаар иргэдийн тав тухтай амьдрах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдийн өмнө тулгараад буй нөхцөл байдалтай танилцан нийслэлийн зүгээс шийдвэрлэх шаардлагатай асуудлыг шийдвэрлэж, зарим төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдэд гурван талт гэрээний үүргийн биелэлтээ ханган иргэдийг орон сууцаар хангах тухай хугацаатай үүрэг даалгавар өгсөн. 2017-2018 онд дээрх аж ахуйн нэгжүүд дахин төлөвлөлтийн төслийн хүрээнд барьж байгаа орон сууцаа ашиглалтад оруулах болно.

Улаанбаатар хотын агаар, хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрт тусгагдсан 7 дугаар хороолол, Буянт-Ухаа, Ирээдүй, Яармаг зэрэг орон сууцны хорооллыг инженерийн шугам сүлжээний ажилд 12.4 тэрбум, гэр хорооллын дахин төлөвлөлттэй холбоотойгоор Баянзүрх дүүргийн орон сууцны 8, 14, 16 дугаар хороолол, Сонгинохайрхан дүүргийн 5, 6 дугаар хороо болон бусад инженерийн шугам сүлжээнд 10.8 тэрбум төгрөгийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлэн хэрэгжүүлж дуусах шатанд байна.

Мөн Хан-Уул дүүргийн Нэхмэлийн шар байр орчмын дахин барилгажуулах төслийн инженерийн шугам сүлжээ, Баянгол дүүргийн дулааны шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэл, Чингэлтэй дүүргийн Дэнжийн 1000, Монголын үндэсний олон нийтийн радио телевиз орчмын хорооллын инженерийн шугам сүлжээний ажилд нийт 11.2 тэрбум төгрөгийг Барилга, хот байгуулалтын сайдын багцын хөрөнгөөс шийдвэрлэн хэрэгжүүлж эхлээд байна.

Түүнчлэн Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан “Нийслэлд 1000 айлын

түр орших орон сууцыг барьж ашиглалтад оруулах” зорилтын хүрээнд гэр хорооллыг дахин төлөвлөж, орон сууцжуулах зориулалтаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас олгох болсон 350,0 сая юанийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн Ногоон нуур орчмын бүсэд 1000 айлын түр орон сууц барих асуудлыг хэрэгжүүлэхээр Хятадын талтай тохиролцон бэлтгэл ажлыг хангуулаад байна. Мөн уг буцалтгүй тусламжийн хүрээнд БНХАУ-ын хөнгөлөлтэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Замын-үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”-ийн туршилт тохируулгад шаардлагатай зардлуудыг санхүүжүүлэхээр санал тавиад байна.

4.2.“Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг боловсруулах ажлын хүрээнд:

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Ногоон хөгжлийн бодлого, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн судалгаа, урьдчилсан техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажил хийгдэж байна.

“Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг боловсруулж, батлуулах ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий үндэсний хороог байгуулах асуудлыг Засгийн газрын 2017 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 1 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлсэн. Тус хуралдааны тэмдэглэлийн дагуу “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах тухай Засгийн газрын 2017 оны 01 дүгээр сарын 04-ний 5 дугаар тогтоолыг баталж, уг төслийг боловсруулж, батлуулах ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий үндэсний хорооны бүрэлдэхүүнийг баталсан. Энэхүү төслийг боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, холбогдох салбарын чиглэлээр судалгаа, тооцоолол, мэдээллээр хангах, санал, зөвлөмж өгөх үүрэг бүхий ажлын хэсгийг Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 43 дугаар тушаалаар байгуулан ажиллуулж байна. Тус ажлын хэсгийн хурлыг 2017 оны 03 дугаар сарын 21-ний өдөр, “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулахад эрдэмтэд, судлаачид, мэргэжилтнүүдийн оролцоо” сэдэвт хэлэлцүүлгийг 2017 оны 03 дугаар 28-ны өдөр тус тус зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт Үндэсний хороо, ажлын хэсэг, зөвлөх баг болон эрдэмтэн, судлаачдын төлөөлөл бүхий нийт 120 хүн оролцсон байна.

Тав.Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн чиглэлээр

Хаягийн мэдээллийн систем байгуулах, Газрын кадастрын мэдээллийн санг геодезийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, Үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцийн суурь мэдээллийг бий болгох зэрэг томоохон төслүүд хэрэгжин энэ онд бүрэн дуусч хэрэглээнд нэвтрүүлэхээр болоод байна.

5.1.Үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцийн суурь мэдээллийг бий болгох ажлын хүрээнд:

“Үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтэц байгуулах тухай” Засгийн газрын 2013 оны 323 дугаар тогтоолыг үндэслэн Үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцийн суурь мэдээллийг бий болгох ажлын хүрээнд хот байгуулалтын бүх үе шатны мэдээллийг нэгтгэх, нэгдсэн зохион байгуулалтад оруулах зорилгоор “Хот байгуулалтын мэдээллийн сан”-г үүсгэх ажлыг гүйцэтгэж байна. Тус мэдээллийн санг үүсгэснээр хот төлөвлөлт, газар зохион байгуулалтын төлөвлөлтүүд хоорондоо харилцан уялдаа, шүтэлцээтэй хэрэгжих, иргэд, нийтийн хэрэглээнд нэвтэрч, интернетийн орчинд хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний мэдээллийг ашиглах, иргэд, олон нийтийн оролцоо, санаачилгаар хот суурины төлөвлөлт, дахин төлөвлөлтийн төслүүдийг хэрэгжүүлэх, хяналт тавих суурь нөхцөл бүрдэх юм.

Энэ ажлын хүрээнд батлагдсан хот төлөвлөлтийн баримт бичгийг тоон байдалд хөрвүүлэх, мэдээллийн санд оруулах ажил 2015 оноос эхлэн хийгдэж, өнөөдрийн байдлаар 44 сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний холбогдох мэдээлэл уг санд бүртгэгдээд байна. Үүнтэй уялдуулан “Хот байгуулалтын мэдээллийн санг ажиллуулах журам”-ын төсөл, “Мэдээллийн сангийн таних тэмдгийн стандарт”-ын төслийг боловсруулж, батлуулах шатанд байна. Дээрх ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна:

- Үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцийн систем, суурь мэдээлэл бүрдүүлэх, вебэд суурилсан геопорталын ТЭЗҮ-ийг боловсруулж дууссан;
- Монгол орны 1:500000 масштабтай уур амьсгал /хур тунадас, салхи, агаарын даралт, температур/-ын мэдээллийн санг бүрдүүлж дууссан;
- Монгол орны 1:100000 масштабтай хөрсний мэдээллийн санг бүрдүүлж дууссан;
- Монгол орны ойн сан, түүнд хамаарагдах газар ашиглалт, хамгаалалт, гэрээгээр эзэмшиж, ашиглаж байгаа ойн сангийн талбай, нөхөн сэргээлтийн хэтийн төлвийн мэдээллийн санг бүрдүүлж дууссан;
- Монгол орны одоо байгаа төрөл бүрийн масштабтай зураг /геологи, геоморфологи, гадаргын хэрчигдэл, шинэ тектоник, газар чичирхийлэл, ашигт малтмал, инженер-геологийн нөхцөл, мужлал, онцгой шинж чанар бүхий ул хөрс, газар хөдлөл, цэвдэг, гидрогеологи, гидрологи, түүх археологи/-ийн мэдээллийн санг бүрдүүлж дууссан;
- Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээг боловсруулах арга зүйг боловсруулсан;
- Нийгэм, эдийн засгийн мэдээлэл бүрдүүлэх программ, мэдээллийн сангийн загварыг боловсруулж дууссан;
- Газрын тохиромжтой байдлын үнэлгээнд нийцүүлэн Монгол Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлыг хийж байгаа бөгөөд ажлыг нэгдсэн удирдлагаар хангах, салбар дундын зохицуулалт хийх үүрэг бүхий ажлын хэсгийг Ерөнхий сайдын 2017 оны 55 дугаар захирамжаар байгуулан ажиллаж байна;
- Монгол Алтайн нуруу болон Алтайн хойд говийн экологийн бүс нутгуудын үнэлгээнд шаардагдах экосистемийн ангилал ба амьтны зүйлийн тархацын загвар болон мэдээллийн санг бүрдүүлж дууссан;

- 1:100000 масштабтай байр зүйн зургийн тодруулалт, шинэчлэлтийн ажлыг гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан ба гэрээт ажлыг 2015 оны 12 дугаар сард акт үйлдэн хүлээн авсан. Энэхүү ажлын үр дүнг байгууллагын орон зайн мэдээллийн дэд бүтэц байгуулах ажилд болоод улсын хэмжээнд ашиглахаар geoportals.mn хуудаст оруулсан;
- Монгол Улсын аймаг, сумын төвийн 1:1000 масштабтай байр зүйн зургийн тодруулалт, шинэчлэлийн ажлыг 330 сум, сууринд гүйцэтгүүлэхээр “Геомастер” ХХК-тай 2013/69 дугаар гэрээ байгуулсан ба 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн байдлаар 369 сум, суурингаас 339 сум, сууринд энэхүү ажлыг гүйцэтгэсэн, гэрээний биелэлт 94 хувьтай байна. Гэрээний хугацаа 2017 оны 05 дугаар сарын 01-ний өдөр дуусна.

5.2.Газрын кадастрын мэдээллийн санг солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд:

Газрын кадастрын мэдээллийн сангийн “Лэнд менежер” програм хангамжийг нэвтрүүлэх, хөгжүүлэх ажлын хүрээнд 232 сумын газрын кадастрын мэдээллийн санг шинэчлэн бүрдүүлж, программ хангамжийг хүлээлгэн өгөөд байна.

Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх ажлын хүрээнд 230 сумын Газрын кадастрын мэдээллийн санг хүлээн аваад байна.

Кадастрын зураг, газрын улсын бүртгэлийн өөрчлөлтийг тогтмол хийж байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 12 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрыг 2 долгионы GPS-ээр хангаад байна.

5.3.Хаягийн мэдээллийн систем байгуулах ажлын хүрээнд:

Улсын хэмжээнд хаягийн мэдээллийн систем байгуулах ажлыг 331 сум, суурин, 9 дүүрэгт гүйцэтгүүлэхээр “Геокад” ХХК-тай 2013/49 дугаар гэрээ байгуулсан ба 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн байдлаар 331 сум, сууринд энэхүү ажлыг гүйцэтгэсэн, гэрээний биелэлт 91.5 хувьтай байна. Гэрээний хугацаа 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдөр дуусна. 2017 онд Улаанбаатар хотын 9 дүүрэгт энэхүү ажлыг газрын албаны болон хорооны мэргэжилтнүүдийн оролцоотой гүйцэтгүүлэхээр сургалтад хамруулсан байна.

Аймаг сум, суурингуудын нутаг дэвсгэрт газар хөдлөлийн бичил мужлалын зураглал хийх, газар хөдлөлийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологи, газар хөдлөлт, техникийн судалгааны ажлыг нийт 12 аймгийн төвд хийж, холбогдох зураг, мэдээллийн санг хүлээн авч хэрэглээнд нэвтрүүлэхээр ажиллаж байна.

“Нийслэл, аймгийн төв, улсын чанартай авто зам дагуух Монгол Улсын иргэнд өмчлүүлэх боломжтой газрын байр зүйн зураглал, газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, газар зохион байгуулалтын төлөвлөгөө

боловсруулах” ажлыг 130400 га газарт хийж, иргэнд улсын чанартай автозам дагуух газарт газар өмчлөх боломжийг бүрдүүллээ.

5.4.Газрын биржийн талаар:

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд газрын цахим биржийг ажиллуулах эрх зүйн орчинг бүрдүүлж, газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг цахимаар зохион байгуулж, оролцогч талуудыг эрх тэгш байдлаар хангах, эдийн засгийг эрчимжүүлэх тухай арга хэмжээ тусгагдсан.

Газрын биржийн үйл ажиллагааны журмыг Засгийн газрын 2016 оны 210 дугаар тогтоолоор баталсан.

2015 оноос газрын цахим биржийг туршилтаар ажиллуулж, 2016 оноос улсын хэмжээнд нэвтрүүлэн, нийт 656 удаагийн газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдааг зарлаж, газар эзэмших, өмчлөх 4569 барьцааг бүртгэж, 8221 газрын худалдагдсан үнийн мэдээг бүртгэлжүүлээд байна.

Цаашид салбарын бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгох чиглэлээр дараах ажлуудыг хийхээр төлөвлөн ажиллаж байна:

-Ипотекийн зээлийн нөхцөлийг хөнгөвчилж, зээлийн хөтөлбөрийг олон хувилбарт хэлбэрээр хэрэгжүүлэх бодлого баримталж, зээлийн цар хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх;

-Хүн амын орон сууцны хэрэгцээг хангах зорилгоор нэгдсэн бодлого боловсруулж, “Хямд өртөгтэй орон сууц” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

-Норм, нормативын баримт бичгийн тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж, олон улсын норм, нормативын баримт бичгийг хэрэглэх орчинг бүрдүүлэх;

-Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг бүс нутаг, бүлэг суурингийн тогтолцоог оновчтой тогтоох чиглэлээр үе шаттайгаар боловсруулах;

-Газрын нэгдсэн бодлого, тогтолцоог бүрдүүлж, газар ашиглах, эзэмших, өмчлөх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;

-Монгол Улсын нутаг дэвсгэрийг бүрэн зурагжуулах, шинэчлэх, геодезийн нэгдсэн сүлжээг бий болгох замаар орон зайн өгөгдөл, мэдээллийг нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх;

-Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан “Гудамж”, “Дугуйн зам” дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;

-Улаанбаатар хотыг хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх;

-Улаанбаатар хот болон томоохон хотуудыг дахин төлөвлөж, хөгжүүлэх бодлогын хүрээнд барилга байгууламжийг шинэчлэх, гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, агаарын бохирдлыг бууруулах нөхцөлийг бүрдүүлэх;

-Хот, суурин газруудад шинээр баригдах орон сууцны хорооллын инженерийн хангамжийн шугам сүлжээний техникийн шийдлийг хонгилын системээр төлөвлөн, үе шаттай хэрэгжүүлэх;

-Барилга байгууламжийн өөрийн өртгийг бууруулах, барилгын үйлдвэрлэлийн хугацааг уртасгах, барилгын жинг хөнгөрүүлэх, дулаан

алдагдлыг бууруулах, галд тэсвэрлэлтийг сайжруулахад чиглэсэн барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

-Хот, суурин газруудын газар хөдлөлтийн үйлчлэлийн давтамж, эрчмийг шинэчлэн тогтоож, барилга байгууламжийн төлөвлөлтөд тусгах, ашиглагдаж буй барилга байгууламжуудын бат бэх, найдвартай байдлыг сайжруулах арга хэмжээг төлөвлөж, үе шаттай хэрэгжүүлэх;

-Нийтийн аж ахуйн талаар төрөөс баримтлах нэгдсэн бодлогыг хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж хэрэгжүүлэх;

-Улаанбаатар хотод шинээртөлөвлөж байгаа орон сууцны хорооллын унд-ахуйн хэрэглээний цэвэр усыг тусад нь төлөвлөх, гарсан бохир усыг саарал усны стандартын шаардлагад нийцүүлэн дахин боловсруулж, ариутгах татуургын системд технологийн зориулалтаар болон ногоон байгууламжийн усалгаанд ашиглах зэрэг техникийн шийдлийг зураг төсөлд тусгаж, хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэх;

-Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хот болон бусад томоохон хот, суурин газрын цэвэрлэх байгууламжийг үе шаттай шинэчлэх ажлыг эрчимжүүлэх;

-Цэвэрлэх байгууламжаар цэвэрлэсэн ус болон хөрсний усыг үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах боломжийг бүрдүүлэх;

-Утасгүй интернетийн хүртээмжийг нэмэгдүүлж, амралт, зугаалгын бүс, номын санд ашиглах боломжийг бүрдүүлэх;

-Улаанбаатар хотын цэвэр усны хангамжийг сайжруулах ажлын хүрээнд Туул, Сэлбэ, Дунд голын урсацыг нэмэгдүүлж, эргийн дагуу олон нийтийн соёл, амралтад зориулсан тохилог орчныг бүрдүүлэх;

-Улаанбаатар хотын орон сууцны хороолол, нийтийн үйлчилгээний төвүүдийн дэргэд газар доорх болон давхар зогсоол барьж, авто зогсоолыг хоёр дахин нэвтрүүлэх;

-Улаанбаатар хотын Сэлбэ, Баянхошуу дэд төвүүдийн инженерийн шугам сүлжээг барьж байгуулах ажлыг дуусгахаар төлөвлөн хэрэгжүүлэх.

ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ЯВЦЫН ТАЛААР

Нэг.Зам, тээврийн салбарын хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар

Зам, тээврийн салбарын хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох ажлын хүрээнд Авто замын тухай болон Усан замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн. Түүнчлэн иргэний нисэх, төмөр замын тээвэр, автотээвэр, далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг тус тус боловсруулж байна.

НҮБ-ын Дугуйт тээврийн хэрэгсэл, тэдгээрт ашиглаж болох тоног, төхөөрөмж болон эд ангид зориулсан техникийн нэгдсэн шаардлагыг батлах тухай, эдгээр шаардлагад үндэслэн олгосон зөвшөөрлийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээрийг Улсын Их Хурлын холбогдох байнгын хороотой зөвшилцөхөөр хүргүүлэхэд бэлтгэж байна.

Дэлхийн худалдааны байгууллагын Иргэний агаарын хөлөг худалдах тухай хэлэлцээрийг Улсын Их Хурлын холбогдох байнгын хороогоор хэлэлцүүлэн дэмжүүлж, уг хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхэд бэлтгэж байна.

Авто зам болон автотээврийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг шинээр, төмөр замын тээвэр болон иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж байна.

Хоёр.Авто замын салбарын бүтээн байгуулалтын ажлын талаар

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдэд авто замын салбарт хэрэгжүүлэхээр тусгагдсан, эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн авто замын сүлжээг бий болгох зорилтын хүрээнд 2017 онд 21 чиглэлийн 1412.77 км хатуу хучилттай авто зам, 3 байршилд 639.6 у/м төмөр бетон болон хөвдөг гүүрийн барилга, их засварын ажлыг улсын төсвийн 5.29 тэрбум төгрөг, Хөгжлийн банкны 23.84 тэрбум төгрөг, гадаадын зээл, тусламжийн 509.93 тэрбум төгрөг, нийт 539.06 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэнэ.

Үүнээс шинээр 7 чиглэлийн 506.5 км авто замын барилга болон их засварын ажлыг эхлүүлэхээр, он дамжин хийгдэж байгаа 14 чиглэлийн 973.26 км авто зам болон 3 байршилд 639.6 у/м төмөр бетон болон хөвдөг гүүрийн барилга, их засварын төслүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.

Тухайлбал, гадаадын зээл, тусламжаар Азийн авто замын сүлжээний АН4 чиглэл буюу баруун босоо тэнхлэгийн Ховд-Баян-Өлгий-Улаанбайшинт чиглэлийн 189.7 км хатуу хучилттай авто замын барилгын ажил, Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км хатуу хучилттай авто зам, Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км хатуу хучилттай авто зам, Улаанбаатар-Хөшигийн хөндийн олон улсын шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн 32.2 км хурдны авто замын барилгын ажил хийгдэж байна.

БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлж буй 3 төсөлд хуваарилагдсан нийт хөрөнгөөс 24.98 сая ам.доллар хэмнэгдсэн. Энэ хөрөнгөөр Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км хатуу хучилттай авто замын барилгын үлдэгдэл ажлыг санхүүжүүлэхээр БНХАУ-ын Эксим банктай тохиролцоод байна.

Авто замын салбарт он дамжин баригдаж буй авто зам, гүүрийг энэ онд дуусган ашиглалтад оруулахаар ажиллаж байгаа бөгөөд Хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй авто зам, гүүрийн барилга угсралтын ажил 80%, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй авто замын барилга, гүүрийн их засварын ажил 60%, төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар /концессын гэрээгээр/ хэрэгжиж авто зам, хөвдөг гүүрийн барилгын ажил 90%-ийн тус тус гүйцэтгэлтэй байна.

Авто замын салбарт 2017 онд дараах 7 чиглэлийн 506.7 км авто замын барилга, их засварын ажлыг шинээр эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна:

- Байдрагийн гүүр-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг концессын гэрээгээр;
- Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг концессын гэрээгээр;
- Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замын төгсгөлөөс Мөрөн-Тариалан чиглэлийн замын төгсгөлийг холбох 120 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг концессын гэрээгээр;
- Жаргалтхаан-Чингис хот чиглэлийн 17 км замын их засварын ажлыг улсын төсвийн хөрөнгөөр;
- Аймгийн төвийн хатуу хучилттай 4.5 км /Баян-Өлгий, Өлгий сум/-авто замын шинэчлэлтийн ажлыг улсын төсвийн хөрөнгөөр;
- Аймгийн төвийн хатуу хучилттай 4.3 км /Ховд, Жаргалант/ авто замын шинэчлэлтийн ажлыг улсын төсвийн хөрөнгөөр;
- Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км хатуу хучилттай авто замын үлдэгдэл барилгын ажлыг БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хэмнэгдсэн хөрөнгийн эх үүсвэрээр тус тус эхлүүлнэ.

Үүнээс гадна Азийн авто замын сүлжээний АНЗ чиглэлийн авто замын хөдөлгөөний эрчим ихтэй хэсэг болох Улаанбаатар-Дархан чиглэлийн 2 эгнээ бүхий 4 дүгээр зэрэглэлийн 220 км авто замыг 1 дүгээр зэрэглэлийн хоёр урсгалтай, 4 эгнээтэй цементбетон хучилттай авто зам болгон өргөтгөн шинэчлэх ажлыг эхлүүлэхээр урьдчилсан судалгааг хийж, зураг төслийг боловсруулж дууссан бөгөөд төр, хувийн хэвшлийн түншлэлийн барих-ашиглах-шилжүүлэх нөхцөлөөр энэ хавраас хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан бүх аймгийн төвийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбож дуусгах зорилтын хүрээнд 2017 онд Дорнод аймаг, 2018-2020 онд Завхан, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс аймгийн төвүүдийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбоно.

Түүнчлэн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн их даацын 250 орчим км авто замын ажлыг энэ оны 5 дугаар сараас эхлүүлж, 18 сарын хугацаанд барьж дуусгахаар ажиллаж байна.

Гурав.Төмөр замын тээврийн салбарын бүтээн байгуулалтын ажлын талаар

Засгийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төмөр замын тээврийн салбарын төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр 2017-2018 онд дараах ажлуудыг гүйцэтгэхээр төлөвлөж байна:

Уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортлоход чухал ач холбогдол бүхий Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын барилгын ажлын явц 51.8%-тай байна. Энэхүү төмөр замын барилгын ажлыг дуусгах асуудлыг Тавантолгойн нүүрсний ордын олборлолтыг эрхлэх сонирхол бүхий хөрөнгө оруулагчтай хэлэлцээ хийж шийдвэрлэхээр ажиллаж байна.

Нарийнсухайтын сав газраас олборлож буй нүүрсний экспортыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын чигийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж баталсан. Тус чиглэлийн төмөр замын ТЭЗҮ, техникийн зураг төслийг хувийн хэвшлийн компаниудын санхүүжилтээр боловсруулж дууссан бөгөөд төслийг энэ жилээс хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Монгол, Орос, Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрт тусгагдсан төмөр замын зүүн коридорыг байгуулах ажлын хүрээнд Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын барилгын ажилд шаардлагатай хөрөнгийг гадаадын зээл, тусламжаар шийдвэрлэж барилгын ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна. Тус чиглэлийн төмөр замын ТЭЗҮ, техникийн зураг төслийг боловсруулж дууссан бөгөөд төмөр замын чигийг баталсан болно. Мөн уг хөтөлбөрт тусгагдсан төмөр замын хойд коридорын Эрдэнэт-Овоот төмөр замыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх концессын гэрээг 2015 онд байгуулсан. Концесс эзэмшигч төмөр замын ТЭЗҮ-ийг 2017 оны 6 дугаар сард боловсруулж дуусгах бөгөөд энэ онд багтаан барилгын санхүүжилтийг шийдвэрлэж, барилгын ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна. Энэхүү төмөр зам баригдсанаар Монгол, Оросын хувь нийлүүлсэн Улаанбаатар төмөр зам нийгэмлэгийн ачаа тээврийн хэмжээ үлэмж нэмэгдэх юм.

Улаанбаатар хотын авто замын хөдөлгөөний ачаалал, агаар, орчны бохирдлыг бууруулахад чухал ач холбогдол бүхий “Богдхан” төмөр замын төслийг Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэхээр санамж бичиг байгуулж, төмөр замын судалгааны ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд боомтын ачаа боловсруулах хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр Замын-Үүд суманд холимог тээврийн логистикийн төвийн бүтээн байгуулалтыг 2016 онд эхлүүлсэн. Ажлын гүйцэтгэл 50 гаруй хувьтай байгаа бөгөөд 2018 онд бүрэн ашиглалтад оруулна. Энэхүү логистикийн төв нь жилдээ 5 сая тонн ачаа боловсруулах хүчин чадалтай байна.

Дөрөв.Автотээврийн салбарын бүтээн байгуулалтын ажлын талаар

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д заасан хэрэглэгчийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн, эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, ая тухтай тээврийн үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлэх зорилтын хүрээнд Дорноговь аймгийн Замын-Үүд сум, Архангай, Хэнтий аймгийн төвүүдэд зорчигч үйлчилгээний авто буудал барих зураг төслийг боловсруулан 2017 оны 5 дугаар сард барилгын ажлыг эхлүүлэхээр бэлтгэл ажлыг хангаад байна.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд дараах ажлууд хийгдэж байна:

- Орос, Монгол, Хятад гурван улсын “Эдийн засгийн коридор байгуулах” хөтөлбөрт тусгагдсан Азийн авто замын сүлжээгээр дамжин өнгөрөх тээвэрлэлт гүйцэтгэх тухай гурван улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн бэлтгэлийг хангах ажлын хүрээнд 2016 оны 8 дугаар сард - Улаан-Үд-Улаанбаатар-Тяньжин чиглэлийн гурван улсын туршилтын дамжин өнгөрөх

тээврийг амжилттай зохион байгуулж, Азийн авто замын сүлжээний АН-3 чиглэлээр дамжин өнгөрөх тээврийг 2018 оны 1 дүгээр сард эхлүүлэхээр хэлэлцээрийг байгууллаа. Цаашид дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлэх зорилгоор Герман, Польш, Чех, Итали, Словак улстай Автотээврийн харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулахаар ажиллаж байна.

- Азийн хөгжлийн банкны техникийн туслалцааны хүрээнд Монгол Улсад тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх стратеги боловсруулах болон замын хөдөлгөөний аюулгүй байдалд аудит хийх тогтолцоог бүрдүүлэх төслүүдийг эхлүүлсэн бөгөөд эдгээр төслүүд нь нэг жилийн хугацаатай үргэлжилнэ.

- Эдийн засгийн хүндрэлтэй байгаа энэ цаг үед уул уурхайн бараа бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх зорилгоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн нүүрс тээвэрлэлтийг хоногийн нэгдсэн графикаар зохион байгуулж байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратегийн хүрээнд дараах ажлууд хийгдэж байна:

- Олон улсын болон улсын чанартай авто замын дагуу жолооч, зорчигчдод үйлчилгээ үзүүлэх, техникийн засвар үйлчилгээ хийх зориулалт бүхий цогцолборуудыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Төв, Сэлэнгэ, Өвөрхангай, Хөвсгөл, Булган, Орхон, Завхан аймагт барьж байгуулахаар зураг төсөл боловсруулж, барилгын ажлуудыг эхлүүлэхэд бэлэн болгов.

- Зам, тээврийн ослоос учирч буй хохирлыг бууруулах зорилгоор олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмж, стандартад нийцүүлэн баруун талдаа жолооны хүрд бүхий тээврийн хэрэгслийн гэрлийн тусгалыг зүүн талдаа жолооны хүрд бүхий тээврийн хэрэгслийн гэрлийн тусгалтай нийцүүлэн өөрчлөх ажлыг эхлүүлээд байна

Тав.Агаарын тээврийн салбарын бүтээн байгуулалтын ажлын талаар

Төв аймгийн Хөшигийн хөндийд баригдаж байгаа олон улсын шинэ нисэх онгоцны буудлын бүтээн байгуулалтын ажлыг техникийн комиссоор хүлээн авч, улсын комисс ажиллаад илэрсэн дутагдал, зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч байгаа бөгөөд улсын комиссын дүгнэлтэд үндэслэн дурдсан дутагдал, зөрчлийг арилгасны дараа комисс дахин ажиллаж ашиглалтад хүлээн авна. Энэ шинэ нисэх онгоцны буудал баригдаж ашиглалтад орсноор Монгол Улсын агаарын тээврийн хөгжилд түлхэц өгч, улмаар дагуул хот, холимог тээврийн логистикийн төв байгуулагдан Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулахад онцгой үүрэг гүйцэтгэх юм..

Говь-Алтай аймгийн Алтай хотын нисэх буудлыг шинэчлэн сайжруулах ажлыг 2016 оны 11 дүгээр сард дуусгаж, ашиглалтад хүлээн авсан.

Люксембургийн Их Вант Улс, Мьянмарын Холбооны Бүгд Найрамдах Улс, Бүгд Найрамдах Чех Улс, Бүгд Найрамдах Мальт Улс, Швейцарийн Холбооны Улс, Тайландын Вант Улс, Камбожийн Вант Улсуудтай байгуулсан агаарын харилцааны хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн байгуулах ажил хийгдэж байна.

Энэ оны 3 дугаар сарын 30-ны өдрөөс Монгол Улсын агаарын зайн үзүүлэлтэд /PBN/ тулгуурласан навигаци бүхий дамжин өнгөрөх нислэгийн 6 замыг агаарын хаалганаас хаалганд чиглэсэн чиг шулуун болгож, Улаанбаатар хотод хөөрөлт, буулт үйлдэх чиг шулуун агаарын зам тогтоон агаарын навигацийн үйлчилгээнд ашиглаж эхэлснээр БНХАУ болон Зүүн өмнөд Азийн хотууд руу нислэг гүйцэтгэж буй дотоодын агаарын тээвэрлэгчдийн нислэг төлөвлөлт хялбаршиж, нислэгийн зам богиносох давуу талыг бий болголоо.

Агаарын замуудыг ийнхүү шулуутгаснаар агаарын тээвэрлэгчид жилд 230 гаруй мянган км зам товчилж, дунджаар 1700 орчим тн түлш хэмнэж, нүүрсхүчлийн хийн ялгаралт 5220 тн-оор багасах тооцоо гарсан.

Зургаа.Далай, усан замын тээврийн салбарын бүтээн байгуулалтын ажлын талаар

Сүүлийн жилүүдэд гадаад, дотоодын аялагч, амрагчдын тоо нэмэгдэж, гол нууруудад усан замын тээврийн хэрэгслээр аялж зугаалах иргэдийн тоо өссөнтэй холбогдуулан дотоодын усан замын тээврийн салбарт зохион байгуулалтыг сайжруулах, тээврийн аюулгүй байдлыг хангах, хяналт хариуцлагыг өндөржүүлэх, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах тогтолцоог бүрдүүлэн ажиллаж байна.

Монгол Улс хөлөг онгоцны бүртгэлийг Сингапурын боомтод эрхэлж байгааг ойрын жилүүдэд Улаанбаатарт төвлөрүүлж бүртгэдэг болох, бүртгэгдсэн хөлөг онгоцны хяналтыг сайжруулах, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх, бүртгэлийг чанаржуулах, улмаар агентын сүлжээг үүсгэх замаар бүртгэлийн ажлыг өргөжүүлэхээр ажиллаж байна.

Далайн боомт ашиглалтын хүрээнд БНХАУ, ОХУ, БНИУ-ын худалдааны далайн боомтуудыг Монгол Улсын гадаад худалдаанд ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ. Тухайлбал, энэ хүрээнд Бүгд Найрамдах Итали Улсын Генуя боомтыг таатай нөхцөлөөр ашиглах талаар тохиролцож байна.

БНХАУ-ын Тяньжин дэх Дунзяны эдийн засгийн чөлөөт бүсийн 10 га газарт тээвэр, логистик, үйлдвэрлэл, үйлчилгээний цогцолбор барьж ашиглах талаар Хятадын талтай тохиролцсон бөгөөд одоогоор төслийг “Монголын төмөр зам” ТӨХК 49%, Хятадын тал 51%-ийн оролцоотойгоор хамтран хэрэгжүүлэхээр хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхээр ажиллаж байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР